



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 79

Мөрөн

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, УИХ-ын 1999 оны 46 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн эрүүл мэндийн салбарт Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг сайжруулах аймгийн дэд хөтөлбөрийг 01 дүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 02 дугаар хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах, Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамруулж санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн /Засаг дарга/ А.Эрдэнэбаатарт даалгасугай.

3. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг жил бүр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын /Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга/ Ж.Ганболд, аймгийн /Эрүүл мэндийн газрын дарга/ Л.Дамдинсүрэн нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн /ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/ С.Цогтоод даалгасугай.

ДАРГА



Т.БОЛДБААТАР

2015

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн
79 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралт

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР 2016-2021 ОНД БАРИМТЛАХ СТРАТЕГИ

Нэг. Үндэслэл

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/ анх 1978 онд уламжлалт анагаах ухаан (УАУ)-ы зарим эм, арга барилыг хүлээн зөвшөөрч, 1990 оноос УАУ-ыг эрүүл мэндийн нэгдсэн тогтолцооныхоо албан ёсны бүрэлдэхүүн хэсэг болгохыг гишүүн орнууддаа уриалсан юм. 2001 онд ДЭМБ-аас батлан гаргасан "УАУ-ны талаар баримтлах дэлхийн стратеги"-ийн баримт бичигт "УАУ гэдэг нь хүний эрүүл энх, сайн сайхан байдлыг бататгах, эмчлэх, оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ургамал, амьтан, эрдсийн гаралтай эмт бодис, бариа заслын болон сэтгэл заслын мэдлэг чадвар, итгэл үнэмшлийг дангаар болон хослуулан хэрэглэхийг хэлнэ" гэж тодорхойлсон билээ. Уг стратегийн баримт бичигт улс орнуудыг эрүүл мэндийн тогтолцоонд нь УАУ-ны гүйцэтгэх үүргийг харгалзан 3 хэлбэрт хувааж үзсэн байна. Үүнд:

1. Нэгдмэл тогтолцоо - УАУ-ыг албан ёсоор хүлээн зөвшөөрч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх шатлалд УАУ-ны эмчилгээ, үйлчилгээг оруулсан;
2. УАУ-ыг агуулсан тогтолцоо - УАУ-ыг хүлээн зөвшөөрсөн боловч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээндээ УАУ-ныг бүрэн хэмжээгээр оруулаагүй;
3. Орчин үеийн тогтолцоо давамгайлсан тогтолцоотой улс орнууд - Үндэсний эрүүл мэндийн тусламжийн тогтолцоо нь бүхэлдээ орчин үеийн анагаах ухаанд суурилсан бөгөөд УАУ-ны эмчилгээ, үйлчилгээний зарим арга барилыг л хуулиар зөвшөөрсөн. Иймд манай улс ДЭМБ-ын гишүүн 192 орноос УАУ-ны үндэсний бодлоготой 25 орны нэг бөгөөд УАУ-ны нэгдмэл тогтолцоотой улс орны тоонд зүй ёсоор орж байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.7-д "Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь харьяа нутаг дэвсгэрийнхээ хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар үзүүлэх ..." гэж

заасан байдаг ба “Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”-ыг УИХ-ын 1999 оны 46 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж эхэлсэн ба энэ нь 2000 гаруй жилийн түүхтэй монгол үндэсний УАУ-ыг дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм. Үүнээс хойш 2009 онд Монголын УАУ-ны анхдугаар чуулган хуралдаж “Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан мөрдүүлэх нь уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, хөгжлийг эрчимжүүлэх болно гэсэн зөвлөмжийг гаргасны дагуу энэхүү бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор “Хөтөлбөр батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2010 оны 386-р тушаалаар “Монголын Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх хөтөлбөр” батлагдсан.

Энэхүү шаардлагын дагуу Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн салбарт уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх чиглэлээр баримтлах стратегийг тодорхойлж, дунд хугацааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж байгаа ба уг стратеги нь ойрын 5 жилийн хугацаанд эрүүл мэндийн салбарт уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлох үндсэн баримт бичиг болно.

Хоёр. Эрүүл мэндийн салбарын уламжлалт анагаах ухааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Манай аймагт уламжлалт анагаах ухааны 16 их эмч, АНЭ-ийн уламжлалтын тасаг, хувийн хэвшлийн хэвтүүлэн эмчлэх 2, амбулаторийн тусламж үзүүлэх 1 эмнэлэг ажиллаж байна.

Уламжлалт анагаах ухааны чиглэлээр Өрхийн эрүүл мэндийн төв-1, Сэтгэцийн эрүүл мэндийн төв-8, Сум дундын эмнэлэг-3 эмч ажиллаж байгаа боловч эдгээр эмч нар УАУ-ны тусламжийг дагнан үзүүлэх боломж багатай, анхан шатны тусламж үйлчилгээнд УАУ-ны эзлэх хувь хангалтгүй байна.

Уламжлалтын чиглэлээр сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдэд их биеийн зүү, гарын зүү, чихний зүү, цахилгаан зүү, бүтэн биеийн бариа, сүүн бариа, халуун тосон бариа, шөлөн бариа, хэсэгчилсэн бариа, хануур засал, самнуур засал, түрэм, төөнө, монгол төөнө, энгийн төөнө, цахилгаан төөнө, энгийн бумба, гулгуур

бумба, жин засалт, ороолт засал, улаан цагаан гаргалт, дэвтээлэг засал зэрэг 7-8 төрлийн эмчилгээнүүд хийгдэж байна.

“Олонд туслах”, “Цээнэ” хувийн хэвшлийн ортой 2 эмнэлэгт 32 ор ажиллаж уламжлал, дотрын тусламж үйлчилгээг хослуулан үзүүлж, хэвтүүлэн эмчлэхээс гадна өвчнийг хүндрэхээс өмнө биемахбодыг өвчнөөс урдчилан сэргийлэх, дархлааг сайжруулах, өвчнийг амирлуулах, өвчтөний биеийг тэнхрүүлэх, сэргээх, сэтгэл санаагаар дэмжиж, эрүүл саруул амьдрах, эрүүл зөв хооллож, ажил амралтаа өвчтөн өөрийнхөө онцлогт тохируулан зөв зохицуулах талаар зөвөлгөөг өгч ажиллаж байна.

- “Цээнэ” эмнэлэг жилд дунджаар нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 43,3%-д УАУ-ны тусламж үйлчилгээг үзүүлж, 30-аад төрлийн эм тангаар 260 хүн, зүү эмчилгээгээр 412 хүн, хануур, самнуураар 703 хүн, төөнүүр эмчилгээгээр 312 хүн эмчилснээс гадна шинээр хаш чулуун эмчилгээний 5 төрлийн аппаратыг оруулан ирж, 8 сараас эхлэн үйл ажиллагаандаа ашиглаж, 130 хүнд үйлчилсэн байна. Мөн бариа заслаар мэргэшсэн бага эмчийг бүрэн орон тоогоор ажиллуулж 7 төрлийн бариа заслыг хийдэг болж нийт 550 хүнд үйлчилсэн.

- “Олонд туслах” эмнэлэг 490 үйлчүүлэгч хэвтүүлэн эмчлэхдээ бүгдэд нь уламжлалт эмчилгээг эмийн эмчилгээтэй хослуулан хэрэглэж хануур, самнуур эмчилгээ 56 хүнд, төөнүүр эмчилгээ 81 хүнд, бумба 73 хүнд, татлага эмчилгээ 18 хүнд, зүү эмчилгээ 490 хүнд, бариа заслаар 490 хүн эмчилсэн байна. Мөн багтраа өвчтэй хүмүүст усан зүүн эмчилгээг, аарцаг нурууны эмгэгтэй хүмүүст хөлөөр хийдэг массажны аргуудыг шинээр нэвтрүүлэн хэрэглэж эхэлснээр багтраа өвчний дахилт, аарцаг нурууны өвдөлтийг багасгасан байна.

Уламжлалт анагаах ухааны оношилгоо эмчилгээ, зөвлөгөө өгөх чиглэлээр амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлдэг “Ончинжалбаа” эмнэлэг үйл ажиллагаа явуулж жилд дунджаар 387 үйлчлүүлэгчдэд зүү төөнүүр, бариа засал, эм тангаар үйлчилж байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн дотрын тасагт уламжлалтын 8 ор ажиллаж байгаа нь нэгдсэн эмнэлгээр хэвтүүлэн эмчлүүлэгчдийн орны 2,7%-ийг эзэлж байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм.

Ардын эмчилгээ нэрийн дор тусгай зөвшөөрөлгүйгээр мэргэжлийн бус иргэд, шаардлага хангахгүй байранд болон гэрээрээ төрөл бүрийн бариа засал хийж,

улсын бүртгэлгүй, чанарын баталгаагүй эм тангаар үйлчилж байгаа тохиолдлууд байна.

Орон нутгийн бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэх нэрээр олон төрлийн эмийн ургамлуудыг зориулалтын бус аргаар түүж түүхий эдээ бэлтгэж замбараагүй худалдаалж байна.

2014 оны уламжлалт анагаах ухааны чиглэлээр хийгдсэн мэдээг авч үзвэл нийт 7918 үзлэг хийгдсэнээс амбулаторид 4332 буюу 54,7%, стационарт 3586 буюу 45,3%-д үйлчилгээ үзүүлсэн байна. Тусламж үйлчилгээний төрлүүдээс хэсэгчилсэн бариа засал /50,8%/ энгийн бумба /23%/, зүү эмчилгээ /5,2%/, төөнө эмчилгээ /4,8%/-ийг тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын УАУ-ны тайлан мэдээг нэгдсэн сүлжээнд оруулахад /Health info V3.0/ УАУ-ны өвчний онош нь ӨОУ-ын 10-р ангиллын дагуу хөрвөөгүйгээс УАУ-ны мэдээллийн баазыг бүрдүүлэхэд бэрхшээлтэй байна.

Гурав. Стратегийн зорилго, зорилтууд:

Зорилго:

Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 46-р тогтоолоор баталсан “Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”, “Хөтөлбөр батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2010 оны 386-р тушаалаар батлагдсан “Монголын Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хүн амд үзүүлэх УАУ-ны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

Зорилтууд :

1. УАУ-ны эрх зүйн орчны хэрэгжилтийг сайжруулах
2. УАУ-ны тусламж, үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх
3. УАУ-ны тусламж, үйлчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх
4. Уламжлалт анагаах ухааны дэд бүтэц болон тусламж, үйлчилгээнд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилт 1-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Аймгийн хэмжээнд баримтлах стратегийг батлуулан мөрдөж ажиллах
2. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт уламжлалт-нөхөн сэргээх тасгийг өргөтгөн төв болгон байгуулах
3. Эрүүл мэндийн газарт Монголын УАУ-ны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, анхан шатны эмнэлгүүдэд УАУ-ны тусламжийг хариуцсан эмчтэй болгож, ажиллах заавар удирдамжийг батлан гаргах
4. УАУ-ны эмч мэргэжилтнүүдийн хангамжийг нэмэгдүүлж, үндсэн чиглэлээр нь ажиллуулах

Зорилт 2-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. УАУ-ны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын тайлан мэдээг нэгдсэн сүлжээнд оруулах
2. Хүн амд уламжлалт эрүүл аж төрөх ёс заншлыг дэлгэрүүлэх, хэвшүүлэх ажлыг зохион байгуулах
3. Өрх, сум багийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд уламжлалт анагаахын тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх аргуудыг өргөнөөр нэвтрүүлэх
4. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн уламжлалт-нөхөн сэргээх төвийн бүтэц, үйл ажиллагааг дэмжин, аймгийн хэмжээний бодлого, үйл ажиллагааг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангуулж, УАУ-ны нарийн мэргэжлийн тусламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх
5. БНХАУ, ӨМӨЗО-ны туршлагыг судлуулж, хамтран мэргэжилтэн сопилцуулж ажиллуулах

Зорилт 3-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Аймгийн хэмжээнд УАУ-ны тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэж байгаа арга туршлагын мэдээллийн сан бүрдүүлж бусад нэгжүүдэд түгээх
2. УАУ-г Орчин үеийн анагаах ухаантай зүй зохистой хослуулах, зэрэгцүүлэн хөгжүүлэх сайн туршлагын мэдээллийн сантай болох
3. УАУ-ын мэдээллийн баазыг ашиглан судалгааны ажлуудыг эмч, мэргэжилтнүүдээр хийлгэж, нотолгоонд суурилсан шийдвэрүүд гаргуулж байх

Зорилт 4-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. УАУ-ны оношлогоо эмчилгээний багаж тоног төхөөрөмжийг тодорхой үе шаттайгаар нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, хөрөнгө оруулалтанд аймгийн бодлогоор дэмжлэг үзүүлэх

2. УАУ-ны салбарт хэрэгжүүлэх төсөл, дэмжлэгийн хэмжээг өргөтгөх гадаад улсын хандивлагчдыг оролцуулах бодлого гаргах

3. Шинэ технологи, техник, арга зүй нэвтрүүлсэн эмч, мэргэжилтнийг урамшуулахад орон нутгийн дэмжлэг үзүүлэх

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, шалгуур үзүүлэлт

Стратеги төлөвлөгөөний салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг нь төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг үнэлэх хяналт-шинжилгээний ажил болно. Хяналт-шинжилгээ нь дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны ахиц, дэвшил (үзүүлсэн тусламж үйлчилгээ, бий болгосон чадавхи, нөөц бололцоо)-д хяналт-шинжилгээ хийх төдийгүй гарсан үр дүн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, хөгжлийг хянахад чиглэнэ. Эрүүл мэндийн газраас стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шат бүрт хийгдэх хяналт-шинжилгээний төрлийг тогтоож, холбогдох талуудтай хамтран хяналт-шинжилгээг хийнэ. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

Шалгуур үзүүлэлт

- УАУ-ны үйл ажиллагаа явуулж байгаа Эрүүл мэндийн байгууллагуудын тоо
- УАУ-ны чиглээр мэргэшсэн мэргэжилтний тоо
- УАУ-ны салбарт хэрэгжүүлсэн төслийн тоо
- Шинээр нэвтрүүлсэн эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, тусламж үйлчилгээний тоо /нэвтрүүлсэн тусламж үйлчилгээ, оруулсан хөрөнгө оруулалт/
- УАУ-ны талаарх олон улсын сайн туршлагыг нэвтрүүлсэн байдал
- Үйл ажиллагаа нь бүрэн цахим хэлбэрт шилжсэн ЭМБ-дын өсөлт
- Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй УАУ-ны төсөл, хөтөлбөрүүдийн тоо /төслийн хөрөнгө оруулалт, гарсан үр дүн/
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын өсөлт

Зургаа. Хугацаа

Стратеги нь 2016-2021 онд хэрэгжүүлнэ.

Долоо. Санхүүжилт

- Улс, орон нутгийн төсөв
- Гадаад, дотоодын байгууллагын хандив, тусламж
- Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
- Өөрийн орлого

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн
79 дүгээр тогтоолын 02 дугаар хавсралт

**УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ СТРАТЕГИЙГ 2016-2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Зорилт, хүрэх үр дүн | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | | | Хариуцах байгууллага | Хамтран ажиллах байгууллага |
|--|---|---|------------------|--|-----------------------|-----------------------------|-----------------------------|
| | | | Төсөв | Хугацаа | Гүйцэтгэлийн үзүүлэлт | | |
| Зорилт 1: УАУ-ны эрх зүйн орчны хэрэгжилтийг сайжруулах | | | | | | | |
| 1.1 | | Аймгийн ИТХТ-ийн хурлын 2015 оны ... тогтоолоор батлагдсан "Аймгийн ЭМС-т УАУ-ыг хөгжүүлэх талаар 2015-2021 онд баримтлах стратеги"-ийг аймгийн хэмжээнд мөрдөж ажиллах | 2016-2021 он | Батлагдсан шалгуур үзүүлэлт | ЭМГ | ЭМБ-ууд | |
| 1.2 | Хүрэх үр дүн: | АНЭ-т уламжлалт, нөхөн сэргээх тасгийг нэгтгэн шинээр зохион байгуулах | 2016 он | Тасаг байгуулагдсан байна | АНЭ | ЭМГ | |
| 1.3 | УАУ-ны эрх зүйн орчны хэрэгжилтийг сайжруулж, бүтэц, үйл ажиллагааг бэхжүүлснээр УАУ-ны хөгжих суурь болно. | АНЭ-т уламжлалт-нөхөн сэргээх тасгийг өргөтгөн төв болгон байгуулах | 2018 он | УАУ-ны мэргэжил арга зүйн нэгдсэн төвтэй болно | ЭМГ АНЭ | ХХЭМБ СЭМТ, ӨЭМТ, СДЭ | |
| 1.4 | | ЭМГ-т МУАУ-ны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтнийг орон тоогоор ажиллуулж, хөтөлбөрийн бодлого чиглэлийг хэрэгжүүлэх | 2018 он | Мэргэжилтэнтэй болж нэгдсэн удирдлагаар хангагдана | ЭМГ | | |
| 1.5 | | Анхан шатны эмнэлгүүдэд УАУ-ны тусламжийг хариуцсан эмчтэй болгож, тэдний ажиллах заавар удирдамжийг батлан гаргах | 2016-2017 он | СЭМТ, ӨЭМТ-дэд УАУ-ны тусламж хариуцсан эмчтэй болж, заавар журмаар хангагдана | ЭМГ | СЭМТ, ӨЭМТ, СДЭ | |

| | | | | | | | |
|-----|--|---|--|-----------|---|-----|---------|
| 1.6 | | УАУ-ны эмч мэргэжилтнүүдийн хангамжийг нэмэгдүүлж, үндсэн чиглэлээр нь ажиллуулах | | 2016-2021 | Жилд 4-5 УАУ-ны мэргэжлийн эмчээр хангагдана. 2016 онд зүү төөнө заслын эмчээр хангагдана. Жилд 1-2 эмчийг мэргэшүүлнэ. | ЭМГ | ЭМБ-ууд |
|-----|--|---|--|-----------|---|-----|---------|

Зорилт 2: УАУ-ны тусламж, үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх

| | | | | | | | |
|-----|--|--|-------|------------------|---|-----|-----------------------------|
| 2.1 | Хүрэх үр дүн 2.1 | УАУ-ны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын тайлан мэдээг нэгдсэн сүлжээнд оруулах /H info/ | | 2016 оноос | УАУ-ны мэдээллийн баазтай болно | ЭМГ | СЭМТ, СДЭ, ЭЭМТ, ХХЭМБ, АНЭ |
| 2.2 | Анхан болон хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээнд УАУ-ны мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн, мэргэжлийн эмч нар чадавхиж тусламжийн чанар сайжирсан байна. | Өрх, сум, багийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд УАУ-ны өвчнөөс сэргийлэх уламжлалт аргууд, уламжлалт анагаахын тусламж үйлчилгээнүүдийг өргөнөөр нэвтрүүлэх | 2 сая | 2016 оноос | Анхан шатны тусламж үйлчилгээнд УАУ нэмэгдэх, НЭМ-ийн арга хүртээмж сайжирна. | ЭМГ | СЭМТ, СДЭ, ЭЭМТ, ХХЭМБ, АНЭ |
| 2.3 | УАУ-ны мэргэжлийн эмч нар чадавхиж тусламжийн чанар сайжирсан байна. | Хүн амд уламжлалт эрүүл аж төрөх ёс заншлыг дэлгэрүүлэх, хэвшүүлэх ажлыг зохион байгуулах | 3 сая | 2016 оноос эхлэн | НЭМ-ийн МСС-ны нэг арга болж хэрэгжсэн байна | ЭМГ | СЭМТ, СДЭ, ЭЭМТ, ХХЭМБ, АНЭ |
| 2.4 | УАУ-ны мэргэжлийн эмч нар чадавхиж тусламжийн чанар сайжирсан байна. | АНЭ-ийн Уламжлалт-нөхөн сэргээх төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг боловсруулж батлуулах | | 2016-2017 он | УНС төв нь стандарттай болсон байна. | АНЭ | ЭМГ |
| 2.5 | УАУ-ны мэргэжлийн эмч нар чадавхиж тусламжийн чанар сайжирсан байна. | АНЭ-ийн Уламжлалт-нөхөн сэргээх төвийг байгуулж, үйл ажиллагааг дэмжин тоног төхөөрөмж, хүний нөөцөөр ханган тогтвортой байдлыг ханган ажиллах | | 2017-2018 он | УНС төв байгуулагдана | АНЭ | ЭМГ |

| | | | | | |
|------|---|--------------------|---|--------------|---|
| 2.6 | АНЭ-ийн УНС төв нь аймгийн хэмжээний УАУ-ыг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангаж, УАУ-ны нарийн мэргэжлийн тусламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллах | 2018 оноос | Төв нь анхан шатны тусламжийг мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллана | ЭМГ, УНС төв | СЭМТ, СДЭ, ӨЭМТ, ХХЭМБ, |
| 2.7 | ӨЭМТ-дэд УАУ-ын өдрийн эмчилгээ, СЭМТ, СДЭ-дэд УАУ-ор бий болгон ажиллуулах | 2016 оноос | УАУ-ны хүртээмж нэмэгдэнэ | ЭМГ | СЭМТ, СДЭ, ӨЭМТ |
| 2.8 | УАУ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа эмч, мэргэжилтний зөвлөгөөн зохион байгуулах | 2016 он 1-р улирал | Зөвлөлдөх уулзалт зохион байгуулагдсан байна. | ЭМГ | УАУ тусламж үйлчилгээ үзүүлж байгаа ЭМБ-ууд |
| 2.9 | Жил бүр 1-2 мэргэжилтнийг БНХАУ, ӨМӨЗО-ны туршлагыг судлуулж, хамтран мэргэжилтэн солилцуулж ажиллуулах | 2016-2021 | Шинэ технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлсэн байна | ЭМГ | УАУ тусламж үйлчилгээ үзүүлж байгаа ЭМБ-ууд |
| 2.10 | Аймгийн ЭМС-т хөгжүүлэх тэргүүлэх чиглэлд УАУ-ыг тусган оруулж, төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх стратегийн хүрээнд УАУ-ны эмнэлгийг шинээр байгуулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах | 2016-2021 | УАУ-ны тусламж үзүүлдэг ЭМБ-ын тоо нэмэгдсэн байна | ЭМБТЗОК, ЭМГ | |

Зорилт 3: УАУ-ны тусламж, үйлчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх

| | | | | | |
|-----|--|------------|---|-----|------------------------|
| 3.1 | Хүрэх үр дүн УАУ-ны тусламж, үйлчилгээнд шинээр нэвтэрсэн болон | 2016 оноос | Мэдээллийн сантай болно | ЭМГ | СЭМТ, СДЭ, ӨЭМТ, ХХЭМБ |
| 3.2 | Аймгийн хэмжээнд УАУ-ны тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэж байгаа арга туршлагауудыг бүртгэн мэдээллийн сан бүрдүүлж, бусад байгууллагуудад түгээж дэлгэрүүлэх | 2016 оноос | УАУ-г Орчин үеийн анагаах ухаантай зүй зохистой хослуулах, зэрэгцүүлэн хөгжүүлэх онол арга зүйн үндэслэлийг | ЭМГ | УАУ тусламж үйлчилгээ |

| | | | | | | | |
|-----|--|---|---------|------------|----------------------------------|-----|------------------------------------|
| | хэрэглэгдэж байсан арга туршлагауудыг бүртгэн мэдээллийн сан бүрдүүлэх | судалж нэвтрүүлсэн сайн туршлагын мэдээллийн сантай болох | 500.000 | 2016 оноос | Судалгааны ажлууд хийгдсэн байна | ЭМГ | ЭМБ-ын эмч, мэргэжилтэн, судлаачид |
| 3.3 | | УАУ-ын мэдээллийн баазыг ашиглан судалгааны ажлуудыг эмч, мэргэжилтнүүдээр хийлгэж, ОПБХ-ыг зохион байгуулж, нотолгоонд суурилсан шийдвэрүүд гаргаж хэрэгжүүлэх | | | | | |

Зорилт 4: Уламжлалт анагаах ухааны дэд бүтэц болон тусламж, үйлчилгээнд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

| | | | | | | | |
|-----------------------|--|---|----------|------------|---|-----|--|
| 4.1 | УАУ-ны чиглэлээр Төр, хувийн хэвшлийн түншлэл сайжирч, шинэ техник, технологи, арга зүй, хөрөнгө оруулалт нэмэгдэнэ. | УАУ-ны оношлогоо эмчилгээний багаж тоног төхөөрөмжийг тодорхой үе шаттайгаар нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, хөрөнгө оруулалтанд аймгийн бодлогоор дэмжлэг үзүүлэх | | 2016 оноос | Тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалт нэмэгдэнэ | ЭМГ | УАУ тусламж үйлчилгээ үзүүлж байгаа ЭМБ, ХХБ |
| 4.2 | | УАУ-ны салбарт хэрэгжүүлэх төсөл, дэмжлэгийн хэмжээг өргөтгөх гадаад улсын хандивлагчдыг оролцуулах бодлого гаргах | | 2016 оноос | Төсөл, хөтөлбөр хэрэгжинэ | ЭМГ | Гадаад, дотоодын хандивлагчид |
| 4.3 | | Хоёр дахь шатлалын үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх оношлогоо эмчилгээний шинэ дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх ХХБ-тай түншлэх замаар түр болон урт хугацаанд гэрээ байгуулж хамтран ажиллах | | 2016 оноос | Гэрээ байгуулсан байна | ЭМГ | ХХБ |
| 4.4 | | Шинэ технологи, техник, арга зүй нэвтрүүлсэн эмч, мэргэжилтнийг урамшуулахад орон нутгийн дэмжлэг үзүүлэх | 5 сая | | Жилд 2 эмчийг шалгаруулж, урамшуулах | | |
| Нийт хөрөнгийн хэмжээ | | | 16,5 сая | | | | |